



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НЭГДСЭН ДҮН /хураангуй/



УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

АГУУЛГА

<u>1. ХҮН АМ</u>	4
<u>2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА</u>	6
<u>3. ШАШИН</u>	7
<u>4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ</u>	8
<u>5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН</u>	9
<u>6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ</u>	9
<u>7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ</u>	11
<u>8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ</u>	12
<u>9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ</u>	166
<u>10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ</u>	18
<u>11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД</u>	24
<u>12. СУУЦНЫ НӨХЦӨЛ</u>	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР	5
ХҮСНЭГТ 2. ДҮҮРГИЙН НИЙТ ХҮН АМЫН ТОО, 2010, 2020 ОНЫ ТООЛЛОГЫН ДҮНГЭЭР	5
ХҮСНЭГТ 3. ДҮҮРГҮҮДИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 2000-2010, 2010-2020 ОН*	5
ХҮСНЭГТ 4. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ УЛСЫН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	7
ХҮСНЭГТ 5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРЛӨӨР, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2020 ОН	8
ХҮСНЭГТ 6. НИЙСЛЭЛИЙН НИЙТ ХҮН АМД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010, 2020 ОН	9
ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН	10
ХҮСНЭГТ 8. НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН	11
ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН	11
ХҮСНЭГТ 10. НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН	12
ХҮСНЭГТ 11. НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	12
ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	13
ХҮСНЭГТ 13. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	15
ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН (МЯН.ХҮН)	20
ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	21
ХҮСНЭГТ 16. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТАЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	21
ХҮСНЭГТ 17. ДҮҮРГҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН	22
ХҮСНЭГТ 18. ДҮҮРГҮҮДИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН	22
ХҮСНЭГТ 19. ДҮҮРГИЙН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН	23
ХҮСНЭГТ 20. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН	24
ХҮСНЭГТ 21. ДҮҮРГИЙН ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН	25
ХҮСНЭГТ 22. ДҮҮРГИЙН ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	25
ХҮСНЭГТ 23. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	27
ХҮСНЭГТ 24. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН	28
ХҮСНЭГТ 25. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


ЗУРАГ 1. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО	4
ЗУРАГ 2. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*	4
ЗУРАГ 3. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН	6
ЗУРАГ 4. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭИ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	8
ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН	9
ЗУРАГ 6. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2020 ОН	11
ЗУРАГ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН	13

ЗУРАГ 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	134
ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН.....	14
ЗУРАГ 10. НИЙСЛЭЛИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ДҮҮРГЭЭР	16
ЗУРАГ 11. ДҮҮРГИЙН ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН..	16
ЗУРАГ 12. НИЙСЛЭЛИЙН ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН.....	17
ЗУРАГ 13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН	18
ЗУРАГ 14. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН	19
ЗУРАГ 15. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН	20
ЗУРАГ 16. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	23
ЗУРАГ 17. ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН	26
ЗУРАГ 18. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН	27

1. ХҮН АМ

Хүн ам орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогоор Баянзүрх дүүргийн нийт хүн ам 377 194, өрхийн тоо 104 764 болсныг тоолж гаргалаа. Үүнээс гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат иргэн 20.7 мянга байна. Дүүргийн нийт хүн амын 48.4 хувь нь эрэгтэйчүүд, 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО



Хүн амын тоо 2020 онд өмнөх 2010 оны тооллогын дүнгээс (277.5 мянга) 84.2 мянган хүнээр өссөн нь 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтөөс 1.5 дахин буурсан байна. Сүүлийн 10 жилийн хүн амын өсөлтийн бууралтыг агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласантай холбон тайлбарлаж болно. Учир нь тухайн үеийн нийслэлийн хүн амын өсөлтийн тавь гаруй хувийг орон нутгаас шилжин ирсэн хүн амын шилжилт хөдөлгөөн буюу механик өсөлт эзэлж байжээ.

ЗУРАГ 2. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*



Тайлбар: *Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо орсон дүнгээр тооцов.

ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1944	41.0	19.3	21.7	88.9
1956	118.4	62.9	55.5	113.3
1963	223.7	116.5	107.2	108.7
1969	267.4	133.3	134.1	99.4
1979	402.3	198.6	203.7	97.5
1989	548.4	271.2	277.2	97.8
2000	760.1	369.1	391.0	94.4
2010	1 240.0	597.3	642.7	92.9
2020	1 539.8	741.2	798.6	92.8

Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоог харуулдаг. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад Улаанбаатар хотын хувьд эрэгтэй, эмэгтэй хүн амын тоо ойролцоо түвшинд байгаа боловч хүйсийн харьцаа 2010 оны тооллогоос ялимгүй буурсан, харин Баянзүрх дүүргийн эрэгтэй, эмэгтэй хүн амын хүйсийн харьцаа 2010 оны тооллогоос ялимгүй өссөн нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 2. ДҮҮРГИЙН НИЙТ ХҮН АМЫН ТОО, 2000, 2010, 2020 ОНЫ ТООЛЛОГЫН ДҮНГЭЭР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
2000	147.4	72.5	74.9	96.7
2010	277.5	134.4	143.1	93.9
2020	361.7	175.3	186.4	94.0

Хүснэгт 1-ээс харахад нийслэлд 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо 1956, 1963 оны тооллогоор хамгийн өндөр түвшинд байсан бол ялангуяа, 1989 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй буурсаар байна. Үүнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, гадаад, дотоод шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тодруулбал, гадаад руу явж байгаа ажиллах хүчний шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг бол хот руу орон нутгаас суралцахаар ирэгсдийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлдэг ба тэдний ихэнх нь хотод үргэлжлүүлэн суурьшдаг, манай улсын эдийн засгийн бас нэг гол түлгүүр болох уул уурхайн хөгжилтэй уялдан ажиллах хүчний шилжилт явагдан, улмаар орд газруудыг түшиглэн хүн амын төвлөрөл үүсч байгаа ба тэнд ажиллагсдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа нь ч хүн амын хүйсийн харьцаа буурахад нөлөөлсөн байж болох юм.

ХҮСНЭГТ 3. ДҮҮРГҮҮДИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 2000-2010, 2010-2020 ОН*


Дүүрэг	Хүн амын тоо		2010/2000 (%)	2020/2010 (%)	Жилийн дундаж өсөлт	
	(мян.хүн)				(%)	
	2010	2020			2000-2010	2010-2020
БҮГД	1 154.3	1 466.1	152.8	127.0	4.8	3.0
Багануур	22.4	28.6	106.1	127.5	0.6	3.1
Багахангай	3.4	4.1	96.4	122.6	-0.3	2.5
Баянгол	178.7	225.8	130.0	126.4	2.7	2.9
Баянзүрх	277.5	361.7	188.2	130.3	8.0	3.4

Налайх	30.2	37.6	127.7	124.9	2.5	2.8
Сонгинохайрхан	257.5	327.6	166.9	127.2	6.1	3.0
Сүхбаатар	127.8	144.4	138.6	113.0	3.5	1.4
Хан-Уул	110.3	187.3	154.4	169.8	4.9	7.8
Чингэлтэй	146.5	149.0	140.4	101.7	3.7	0.2

Тайлбар: *Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо ороогүй дүнгээр тооцов.

Тооллого хооронд Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн ам өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд хүн ам 0.2-1.4 хувь буюу хамгийн бага өсөлттэй байхад Хан-Уул дүүргийн хүн амын өсөлт 7.8 хувь байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 2.6 дахин өндөр өсөлттэй байна. Үүнийг сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууцны хорооллууд ихээр баригдсантай холбон тайлбарлаж болно. Баянзүрх дүүргийн хүн амын жилийн дундаж өсөлт 3.4 байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 0.4 пунктээр өндөр байна.

ЗУРАГ 3. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Дүүргийн хүн ам насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байна. Нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 оны тооллогоос 7.0 пунктээр нэмэгдэж, эсрэгээр хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 8.7 пунктээр буурчээ.

Голч насыг тооцож үзэхэд ерөнхийдөө залуу хандлагатай ба 1989 онд 20.6, 2000 онд 23.5, 2010 онд 25.6, 2020 онд 28.7 байна. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 57.0 болж 2010 оны тооллогоос 16.3 пунктээр өссөн байна.

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн. Тооллогын үр дүнгийн танилцуулгад бүлэгт 100-аас цөөн хүн амтай бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно.

Баянзүрх дүүрэгт оршин суугаа Монгол Улсын харьяат 356 422 хүн амын 90.2 хувийг

Халхууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 77 237 хүнээр буюу 1.2 пунктээр өссөн байна. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Халхуудаас гадна өсөлт үзүүлсэн угсаатан бол Дарьгангачууд (0.4 пункт) байлаа. Харин Казах, Дөрвөд, Хотгойд, Буриад, Баяд, Өөлд, Урианхай, Захчин, Хотгойдуудын нийт хүн амд эзлэх хувь 0.01-0.5 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 4. БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Үндэс, угсаа	2010		2020*	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ-БҮГД	274 566	100.0	356 422	100.0
Халх	244 361	89.0	321 598	90.2
Казах	2 439	0.9	2 498	0.7
Дөрвөд	6 653	2.4	7 789	2.2
Буриад	5 262	1.9	5 160	1.4
Баяд	4 675	1.7	5 335	1.5
Дарьганга	1 684	0.6	3 450	1.0
Урианхай	1 583	0.6	1 709	0.5
Захчин	2 298	0.8	2 791	0.8
Дархад	496	0.2	592	0.2
Торгууд	1 428	0.5	1 869	0.5
Өөлд	1 60+	0.6	1 466	0.4
Хотон	332	0.1	347	0.1
Мянгад	409	0.1	480	0.1
Барга	214	0.1	183	0.1
Хотгойд	428	0.2	202	0.1
Сартуул	156	0.1	295	0.1
Бусад	465	0.2	254	0.1
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	74	0.0	404	0.1

Тайлбар: *Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй


3. ШАШИН

Шашин шүтдэг эсэх талаар хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа асуулга авч байсан бол энэ удаа тооллогын асуумжид дахин оруулсан юм. Хүн ам орон сууцны тооллогод “Та шашин шүтдэг үү, тэгвэл ямар шашин шүтдэг вэ гэсэн асуултыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан.

Дүүргийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй нийт сүм хийд 2019 онд 99 байна. Сүм хийдийг шашны төрлөөр авч үзвэл 23.2 хувь нь буддын, 68.7 хувь нь христийн, 2.0 хувь нь католик, 4.0 хувь нь бөөгийн, 2.0 хувь нь бусад шашны сүм хийдүүд тус тус эзэлж байна.

Баянзүрх дүүргийн 15, түүнээс дээш насны хүн амын 50.5 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг, 49.5 хувь нь шашин шүтдэггүй, гэж хариулсан ба 2010 оны тооллогын үетэй харьцуулахад шашин шүтдэг гэж хариулсан хүн амын хувь 10.2 пунктээр буурчээ.

ЗУРАГ 4. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭИ ХҮН АМ, ШАШНЫ



Шашин шүтдэг хүн амын тоог шүтдэг шашных нь төрлөөр авч үзэхэд 90.0 хувь нь буддын шашин болон бөө мөргөлийг шүтдэг ба энэ нь 2010 оноос 1.6 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТДЭГ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Шашны төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0
Будда	88.0	89.0	87.5
Ислам	0.9	1.0	0.9
Бөө	5.5	5.0	5.6
Христ	4.0	3.0	4.7
Бусад	1.6	2.0	1.4

Дүүргийн арван тав, түүнээс насны шашин шүтдэг хүн амын 42.7 хувийг эрэгтэйчүүд, 57.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Монгол Улсын нийт хүн амын 45.9 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод, тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 24.7 хувь нь Баянзүрх дүүрэгт суурьшиж, нийслэлийн нийт хүн амд Баянзүрх дүүргийн хүн амын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад 0.7 пунктээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6. НИЙСЛЭЛИЙН НИЙТ ХҮН АМД БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2000, 2010, 2020 ОНООР


Он	Нийслэлийн нийт хүн амын тоо (мян.хүн)	Баянзүрх дүүргийн нийт хүн амын тоо (мян.хүн)	Нийслэлийн нийт хүн амд дүүргийн хүн амын эзлэх хувь
2000	760.1	147.4	19.4
2010	1154.3	277.5	24.0
2020	1466.1	361.7	24.7

Дүүргийн хүн амын нийслэлийн нийт хүн амд эзлэх хувь 2000-2010 оны хооронд 4.6 хувь байсан бол 2010-2020 оны хооронд 0.7 пунктээр нэмэгдэж өсөлтийн хувь буурсан нь агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласантай холбоотой.

5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын товын үед нийслэлийн суурин хүн амын 64.6 хувь нь Улаанбаатар хотод төрөөд, төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд оролгүй нийслэл хотдоо амьдарч буй уугуул хүмүүс байна. Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 35.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 11.8 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 5. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН



6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Хүн амын үзүүлэлтүүдээс боловсрол, бичиг үсэг тайлагдалт нь хүний хөгжлийн явцыг илтгэдэг.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлд “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ”¹ гэж заасан үндсэн агуулгад сүүлчийн тооллогуудын асуулга, аргачлал, заавар, үр дүн нийцэж байгаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолмол аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн гишүүдээс бичиг үсэг тайлагдалтын талаарх мэдээллийг авсан. Тиймээс 2020 оны тооллогын бичиг үсэг тайлагдалтын талаарх тоо мэдээллийг 2010 оны тооллогын дүнтэй хувийн жингээр

харьцуулна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын асуулгын хуудсанд боловсролын түвшний холбогдох асуултыг 6, түүнээс дээш насны бүх хүнээс асуудаг байсан бол 2020 оны тооллогоор 5, түүнээс дээш насны хүнээс, 2-39 насны хүнээс сургуульд сурдаг, цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг асуусан.

БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд боловсролын тогтолцоог шинэчилж, хөгжингүй орны боловсролын стандартыг нэвтрүүлж байна. Тиймээс тооллого хоорондын хүн амын боловсролын түвшинг зэрэгцүүлэн жишиж өөрчлөлтийг харах нь чухал юм. Хүн амын боловсролын түвшинг НҮБ-ын зөвлөмж, олон улсын нийтлэг жишгийг харгалзан 10, түүнээс дээш насныханд тодорхойлов.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын 1 439 болон ерөнхий боловсролын 820, нийт 2259 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 943 (41.7%) нь нийслэл Улаанбаатар хотод байрладаг. Тодруулбал, улсын хэмжээний нийт цэцэрлэгийн 685 (47.6%), ерөнхий боловсролын сургуулийн 258 (31.5%) нь Улаанбаатарт байна. Харин Баянзүрх дүүрэгт 192 цэцэрлэг, 58 ерөнхий боловсролын сургууль байрлан үйл ажиллагаа явуулдаг.

ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, 2010, 2020 ОН

Он	Дүүрэг	Бүгд	Боловс- ролгүй	Боловс- ролтой	Үүнээс: Боловсролын төвшин					
					Дээд	Тусгай мэргэж- лийн дунд	Техникийн болон мэргэж- лийн	Бүрэн дунд	Суурь	Бага
2010	Нийслэл	100.0	3.7	96.3	27.1	6.4	2.1	40.8	11.3	8.6
	Баянзүрх	100.0	3.5	96.5	27.3	6.2	2.1	41.9	10.7	8.3
2020	Нийслэл	100.0	4.1	95.9	36.3	5.3	3.0	32.7	9.4	9.2
	Баянзүрх	100.0	4.1	95.9	38.5	5.3	2.6	32.3	8.3	8.9

Арав, түүнээс дээш насны суурин хүн амын боловсролын түвшнийг нийслэлийн дундаж түвшинтэй харьцуулан үзэхэд дээд боловсролтой хүн амын хувийн жин 2010 оны тооллогоос 11.2 пунктээр нэмэгдэж нийслэлийн дундажаас 2.2 пунктээр өндөр, тусгай мэргэжлийн дунд мэргэжилтэй хүн амын хувийн жин 2010 оныхоос 0.9 пунктээр буурч, нийслэлийн дундажтай ижил, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хувийн жин 2010 оныхоос 0.5 пунктээр буурч, нийслэлийн дундажаас 0.4 пунктээр бага, бүрэн дунд боловсролтой хүн амын хувийн жин 2010 оныхоос 9.6 пунктээр буурч нийслэлийн дундажаас 0.4 пунктээр бага, суурь боловсролтой хүн амын хувийн жин 2010 оныхоос 2.4 пунктээр буурч, нийслэлийн дундажаас 1.1 пунктээр бага, бага боловсролтой хүн амын хувийн жин 2010 оныхоос 0.6 пунктээр нэмэгдсэн ч нийслэлийн дундажаас 0.3 пунктээр бага байна. Боловсролгүй хүн амын эзлэх хувь 2010 оны тооллогоос 0.6 пунктээр нэмэгдэж нийслэлийн дундажтай ижил байна.

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Бичиг үсгийн мэдлэгийн тодорхойлолтын талаарх НҮБ-ын зөвлөмжийг 2000 оноос хойших гурван удаагийн тооллогод баримталсан. Арга зүйн хувьд аль нэг хэлээр энгийн өгүүлбэрийг уншиж ойлгодог, бичиж чаддаг хүнийг бичиг үсэг мэддэг гэж үзсэн.

ЗУРАГ 6. ЗУРГАА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2020 ОН



Зургаа, түүнээс дээш насны суурин хүн амын 34.2 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой байна.

7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийслэлийн нийт өрхийн тоо 2010 оноос 36.1 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын хэмжээнд 411.4 мянган өрх тоологдсоноос Баянзүрх дүүрэгт 104.7 мянган өрх тоологдсон байна.

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Дүүрэг	2010		2020		2020 2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
БҮГД	302 242	100.0	411 420	100.0	136.1
Багануур	6 430	2.1	8 133	2.0	126.5
Багахангай	952	0.3	1 131	0.3	118.8
Баянгол	47 507	15.7	62 976	15.3	132.6
Баянзүрх	73 376	24.3	104 764	25.5	142.8
Налайх	8 093	2.7	10 248	2.5	126.6
Сонгинохайрхан	65 866	21.8	93 521	22.7	142.0
Сүхбаатар	33 513	11.1	40 061	9.7	119.5
Хан-Уул	28 782	9.5	51 241	12.5	178.0
Чингэлтэй	37 723	12.5	39 345	9.6	104.3

Дүүргийн өрхийн тоо 2010 онд 73.4 мянга байсан бол 2020 оны тооллогоор 104.7 мянган болж 42.8 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН

Өрхийн хэлбэр	2010		2020		2020 2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
БҮГД	104 764	100.0	104 764	100.0	136.1
Ганц бие	7 519	10.2	16 987	14.6	208.8

Ам бүлээрээ	39 240	53.5	56 676	52.4	132.4
Нийлмэл	24 619	33.6	27 095	28.9	115.4
Холимог	1 998	2.7	4 006	4.1	219.1

Тооллогоор дүүргийн нийт өрхийн 54.1 хувийг ам бүлээрээ байгаа өрх, 25.9 хувийг нийлмэл өрх, 16.2 хувийг ганц бие өрх, 3.8 хувийг холимог өрх эзэлж байна.

ХҮСНЭГТ 10. НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, АМ БҮЛИЙН ТОО, ХУВИАР, 2020 ОН

Он	Дүүрэг	Бүгд	Ам бүлийн тоогоор				Өрхийн ам бүлийн дундаж тоо
			1-2	3-4	5-6	7, түүнээс дээш	
2010	Нийслэл	100.0	24.9	47.3	22.1	5.7	3.7
	Баянзүрх	100.0	25.9	47.7	21.4	5.0	3.6
2020	Нийслэл	100.0	30.7	38.2	22.9	8.2	3.6
	Баянзүрх	100.0	32.8	38.7	21.7	6.8	3.5

Нийслэлд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь 2010 оны ам бүлийн дундаж тооноос 0.1 пунктээр, Баянзүрх дүүрэгт 3.5 болсон нь 2010 оныхоос мөн 0.1 пунктээр буурсан байна. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгдсөн нь шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид, болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм.

8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Улсын хэмжээнд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаа нь хүн амын 3.3 хувийг эзлэж, 2010 оноос 0.8 пунктээр буурсан байна. Үүнээс 36.7 мянга буюу 34.5 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэл хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүн байгаа нь суурин хүн амын 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 0.9 пунктээр бага үзүүлэлттэй юм.

Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй нийт 7.9 мянган хүний 4.2 мянга буюу 54.0 хувь нь эрэгтэй, 3.6 мянга буюу 46.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 11. НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд			Хүйс			Нийт хүн амд эзлэх хувь
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	эрэгтэй	Эзлэх хувь	эмэгтэй	Эзлэх хувь	
БҮГД	36 685	100.0	20 198	100.0	16 487	100.0	2.5
Багануур	1 092	3.0	623	3.1	469	2.8	3.8
Багахангай	168	0.5	96	0.5	72	0.4	4.1
Баянгол	5 149	14.0	2 778	13.8	2 371	14.4	2.3
Баянзүрх	7 883	21.5	4 260	21.1	3 623	22.0	2.2
Налайх	1 566	4.3	934	4.6	632	3.8	4.2
Сонгинохайрхан	8 349	22.8	4 588	22.7	3 761	22.8	2.5
Сүхбаатар	3 413	9.3	1 892	9.4	1 521	9.2	2.4
Хан-Уул	4 527	12.3	2 525	12.5	2 002	12.1	2.4
Чингэлтэй	4 538	12.4	2 502	12.4	2 036	12.3	3.0


ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Төрөл	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрөл			
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Төрөлхийн	Дүнд эзлэх хувь	Олдмол	Дүнд эзлэх хувь
БҮГД	7 883	100.0	4 165	100.0	3 718	100.0
Хүйс						
Эрэгтэй	4 260	54.0	2 195	52.7	2 065	55.5
Эмэгтэй	3 623	46.0	1 970	47.3	1 653	44.5
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр						
Харааны	943	12.0	564	13.6	379	10.2
Ярианы	237	3.0	200	4.8	37	1.0
Сонсголын	753	9.5	506	12.2	245	6.6
Хөдөлгөөний	1 689	21.4	843	20.2	846	22.8
Сэтгэцийн	1 558	19.8	1 026	24.6	532	14.3
Хавсарсан	387	4.9	229	5.5	158	4.2
Бусад*	2 318	29.4	797	19.1	1 521	40.9


Тайлбар: * Хавсарсан болон бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийг энд оруулав

Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 4 165 (52.8%) нь төрөлхийн, 3 718 (47.2%) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

ЗУРАГ 7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН




ЗУРАГ 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Монгол Улсад оршин суугаа хүн амын бараг хоёр хүн тутмын нэг нь, ойролцоогоор хөгжлийн бэрхшээлтэй гурван иргэн тутмын нэг нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэлийн хүн амд хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувийн жин дундажаар 2.5 хувьтай бол тухайн дүүргийн хүн амд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг гаргаж үзэхэд Багануур (3.8%), Багахангай (4.1%), Налайх (4.2%), Чингэлтэй (3.0%) дүүргүүд нийслэлийн дундажаас 0.5-1.7 пунктээр өндөр, харин Баянзүрх дүүрэгт (2.2%) нийслэлийн дундажаас 0.3 пунктээр бага байна.

ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүний нас, хүйсийн суваргаас харахад 15-19 насны бүлгээс дээш 55-59 насны бүлэг хүртэл, нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо аль ч хүйсэнд өсч байснаа 60, түүнээс дээш насанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо огцом буурч байгаа нь нас баралттай холбоотой. Мөн 54-69 насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо

эмэгтэйчүүдээс илүү байгаа нь ажиглагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 7.9 мянган хүний 2.2 мянга буюу 27.8 хувь нь төрөлхийн, үлдсэн 5.7 мянга буюу 72.2 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна.

Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүний 12.0 хувь буюу 0.9 мянган хүн харааны, 3.0 хувь буюу 0.2 мянган хүн ярианы, 9.5 хувь буюу 0.8 мянган хүн сонсголын, 21.4 хувь буюу 1.7 мянган хүн хөдөлгөөний, 19.8 хувь буюу 1.6 мянган хүн сэтгэцийн, 4.9 хувь буюу 0.4 мянган хүн хавсарсан, 29.4 хувь буюу 2.3 мянган хүн “Бусад” төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөлд дараах өөрчлөлт оржээ. Тодруулбал, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь 2010 оноос 0.2 пунктээр буурсан бол эсрэгээр мөн тийм хэмжээгээр олдмол хөгжлийн бэрхшээл өссөн байна.

ХҮСНЭГТ 13. АРВАН НАЙМ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛИЙН ХЭЛБЭР, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Хүндрэлийн хэлбэр					
		Харааны	Сонсголын	Алхах	Ой тогтоолт /санах/	Өөртөө анхаарал тавих	Харилцах
Насны бүлгийн дүнд эзлэх хувиар							
Бүгд	100.0	20.4	16.1	29.7	11.5	12.3	10.0
18-19	100.0	13.5	10.8	18.9	18.9	16.2	21.7
20-24	100.0	25.8	16.1	12.9	16.1	9.7	19.4
25-29	100.0	25.0	12.5	16.7	18.1	15.3	12.5
30-34	100.0	20.7	18.1	24.1	12.9	9.5	14.7
35-39	100.0	24.8	16.8	22.8	13.9	5.9	15.8
40-44	100.0	16.4	18.6	22.9	17.1	8.6	16.4
45-49	100.0	26.7	14.9	24.8	11.2	9.3	13.0
50-54	100.0	24.9	15.6	32.9	9.2	9.8	7.5
55-59	100.0	20.8	14.2	34.9	10.4	10.8	9.0
60-64	100.0	20.3	14.5	40.1	7.6	10.5	7.0
65-69	100.0	23.5	13.4	38.3	10.7	9.4	4.7
70+	100.0	17.1	17.6	30.6	10.7	16.3	7.8
Хүндрэлийн хэлбэрийн дүнд эзлэх хувиар							
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
18-19	1.7	1.1	1.1	1.0	2.8	2.2	3.7
20-24	2.8	3.6	2.8	1.2	4.0	2.2	5.5
25-29	3.3	4.0	2.6	1.9	5.2	4.1	4.1
30-34	5.3	5.4	6.0	4.3	5.9	4.1	7.8
35-39	4.6	5.6	4.8	3.5	5.5	2.2	7.3
40-44	6.4	5.2	7.4	4.9	9.5	4.5	10.5
45-49	7.3	9.6	6.8	6.2	7.1	5.6	9.6
50-54	7.9	9.6	7.6	8.8	6.3	6.3	5.9
55-59	9.7	9.9	8.5	11.4	8.7	8.6	8.7

60-64	7.8	7.8	7.0	10.6	5.1	6.7	5.4
65-69	6.8	7.8	5.7	8.7	6.3	5.2	3.2
70+	36.4	30.4	39.7	37.5	33.6	48.3	28.3


Дүүргийн нутаг дэвсгэрт оршин суух үйлдлийн чадварын хүндрэлтэй нийт иргэдийн 47.0 хувь нь эрэгтэй, 53.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь харааны хүндрэл байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс насныхны хувьд харааны болон алхах хүндрэлүүд байна.

9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Баянзүрх дүүргийн 6, түүнээс дээш насны хүн амын 91.9 хувь буюу 282.4 мянган иргэн гар утас хэрэглэж байгаа ба 2010 оны тооллогын үеэс 4.2 хувиар нэмэгджээ. Гар утас хэрэглэгчдийн 47.0 хувийг эрэгтэй, 53.0 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

ЗУРАГ 10. НИЙСЛЭЛИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ДҮҮРГЭЭР



Баянзүрх дүүргийн хүн амын гар утасны хэрэглээг нийслэлийн дундаж болон бусад дүүрэгтэй харьцуулан авч үзвэл нийслэлийн дундажаас 0.7 пунктээр илүү, хамгийн өндөр хувьтай Баянгол дүүргийнхээс (92.4%) 0.5 пунктээр байна.

ЗУРАГ11. ДҮҮРГИЙН ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН




ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН

Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 6, түүнээс дээш насны нийт хүн амын 76.0 хувь буюу 946.7 мянган хүн интернэт хэрэглэж байгаа бөгөөд интернэт хэрэглэгчдийн хувь 2010 оноос 26.7 пунктээр өсчээ. Эдгээрийн 47.4 хувь нь эрэгтэй, 52.6 хувь нь эмэгтэйчүүд байв.


ЗУРАГ 12. НИЙСЛЭЛИЙН ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН



Нийслэлийн интернэт хэрэглэдэг иргэдийн 95.4 хувь нь төвийн 6 дүүргийн иргэд байна. Хүн амын интернэтийн хэрэглээгээр нийслэлийн Баянзүрх (25.3 хувь), Сонгинохайрхан (22.1 хувь) Баянгол (16.0 хувь) дүүрэг тэргүүлж, өөрөөр хэлбэл, нийслэлийн интернэт хэрэглэдэг 4 хүн тутмын нэг нь Баянзүрх дүүрэгт, 5 хүн тутмын нэг нь Сонгинохайрхан дүүрэгт амьдарч байна.

ЗУРАГ 13. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,

ДҮҮРГЭЭР, 2010, 2020 ОН



Улаанбаатар хотын хүн амын интернет хэрэглээг дүүргээр авч үзвэл Баянгол (83.2%), Хан-Уул (79.5%), Баянзүрх (77.6%), Сүхбаатар (77.3%) дүүрэгт нийслэлийн дунджаас 1.3-7.2 пунктээр өндөр, алслагдсан дүүргүүдээс Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 67.9 хувьтай байна. Энд онцолж хэлэхэд Багануур дүүргийн интернет хэрэглээ 2010 оны мөн үеэс 2.5 дахин нэмэгджээ.

10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг гаргах нь хэд хэдэн шалтгаантай байдаг. Хүн амын эдийн засгийн талаарх мэдээлэл нь тухайн улс орны эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн хэв маяг, зах зээлийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн цар хүрээ зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Хүн ам, орон сууцны тооллогоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг засаг захиргааны хамгийн бага нэгжийн түвшинд гаргах боломжтойгоороо бусад төрлийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаануудаас давуу талтай.

Энэ удаагийн тооллого нь бүртгэл болон уламжлалт хосолсон аргаар явагдсан ба энгийн санамсаргүй түүвэрт сонгогдсон өрхийн 15, түүнээс дээш насны хүн амаас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг асуусан. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын уламжлалт асуулгын эдийн засгийн идэвхийн үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар шинэчлэн баталсан аргачлалын дагуу тооцсон. Уламжлалт тооллогын асуулгаар “Тооллогын товын үед ажил эрхэлж байгаа эсэх, товоос өмнөх 7 хоногт ядаж нэг өдөр цалин хөлстэй ажил эрхэлсэн болон тухайн хугацаанд ажил эрхлээгүй боловч ер нь ажилтай хүнийг “Ажил эрхэлдэг” гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвхийг долоо хоногийн байдлаар тухайн үеийн идэвх гэсэн ойлголтоор тодорхойлсон. Өвчтэй, жирэмсний болон төрсний дараах чөлөөтэй, ээлжийн амралттай зэрэг шалтгаанаар тооллогын товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй боловч үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэйгээ хөдөлмөрийн гэрээгээ цуцлаагүй, тодорхой хугацааны дараа ажилдаа эргэн орох хүмүүсийг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин бүртгэлд суурилсан мэдээлэл боловсруулалтад Хүн ам, өрхийн мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон Гадаадын иргэн харьяатын газрын гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн сантай уялдуулан ажил эрхэлдэг хүнийг гаргасан.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултыг 15, түүнээс дээш насны бүх хүнээс асуусан.


ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН БАЙДАЛ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвхийг тооллогод тухайн үеийн ажил эрхлэлтээр авсан учир ажиллах хүч (зарим тохиолдолд эдийн засгийн идэвхтэй хүн амтай тохирдог), ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж 2 ангилж тодорхойлов. /Зураг 10.1/. Ажиллах хүчинд ажил эрхэлж байгаа хүн ам болон ажилгүй иргэдийг хамруулдаг. Энэ нь цаашдаа улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог.

Уламжлалт тооллогоор тухайн үед ажиллаж байгаа гэдэг ойлголтод байнгын болон улирлын чанартай ажилтай, тооллогын үед ажил эрхлэхгүй байгаа ч ер нь ажил эрхэлдэг хүн амыг болон бүртгэлд суурилсан тооллогоор нийгмийн даатгал төлөгчдийн мэдээллийн сан болон гадаад, харьяалалгүй иргэдийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил эрхэлдэг бүх хүн амыг ажил эрхэлдэг гэж үзсэн.

Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амд (эдийн засгийн идэвхгүй хүн ам) хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлээгүй хүмүүсээс гадна тохирох ажил олдохгүй байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг оруулдаг.

ЗУРАГ 14. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН




Ажил эрхэлдэг хүн амын тоо 123.5 мянга болж 2010 оноос 28.6 мянган хүнээр буюу 30.1 хувиар өссөн нь эерэг үр дүн байлаа. Хүйсээр авч үзвэл ажил эрхэлдэг хүн амын 50.4 хувь (62.3 мянган хүн) эрэгтэйчүүд, 49.6 хувь (61.2 мянган хүн) эмэгтэйчүүд байна.

Дүүргийн арван тав, түүнээс дээш насны хүн амын 50.6 хувь нь ажил эрхэлж байгаа нь

улсын дунджаас 3.2 пунктээр доогуур байна. Энэ нь *нэгдүгээрт*, нийслэлд их, дээд сургууль олноор төвлөрч, суралцагчдын тоо байнга нэмэгдэж байгаа, *хоёрдугаарт*, хүн ам хэт төвлөрснөөс үүдэн ажлын байрны олдоц ховор байгаа, *гуравдугаарт*, хэдийгээр сүүлийн гурван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхой хэмжээгээр хязгаарласан боловч өмнөх он жилүүдэд шилжин ирэгсэдийн тоо өндөр байсан зэрэгтэй холбоотой.

Ажиллах хүч (эдийн засгийн идэвхтэй хүн ам)-ийг 15, түүнээс дээш насны хүн амд харьцуулж ажиллах хүчний оролцооны түвшнийг тодорхойлдог.

ЗУРАГ 15. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХУВИАР, 2020 ОН



Баянзүрх дүүрэгт арван тав, түүнээс дээш насны хүн амын 60.9 хувь буюу 148.7 мянган хүн ажиллах хүчинд багтаж байгаагийн дотор 83.0 хувь нь ажил эрхлэгчид, 17.0 хувь ажил хайж буй хүн ам эзэлж байна. Ажиллах хүчний оролцооны түвшнийг 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад 9.3 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН, (мян.хүн)

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	123.5	62.3	61.2
15-19	1.1	0.7	0.4
20-24	8.6	4.5	4.1
25-34	44.7	23.1	21.6
35-44	36.3	17.9	18.5
45-54	23.8	10.9	12.9
55-59	5.9	3.3	2.5
60+	3.1	1.9	1.2

Дүүргийн ажиллах хүчний оролцооны түвшнийг насны бүлгээр авч үзэхэд 15-24 насанд хамгийн бага (15-19 насны бүлэгт 1.1%, 20-24 насны бүлэгт 4.5 хувь) байгаа нь хүүхэд, залуучуудын сургуульд хамрагдалттай, мөн их, дээд сургууль төгссөний дараа залуучуудад ажлын байрны олдоц хангалтгүй байдагтай холбон тайлбарлаж болох юм.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Мян.хүн			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	123.5	62.3	61.2	100.0	50.4	49.6
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.1	1.3	0.8	1.7	2.1	1.3
Уул уурхай, олборлолт	4.7	3.6	1.0	3.8	5.8	1.7
Боловсруулах үйлдвэрлэл	10.8	5.4	5.4	8.8	8.7	8.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.3	0.9	0.4	1.1	1.5	0.6
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1.0	0.5	0.5	0.8	0.8	0.8
Барилга	10.2	7.5	2.8	8.3	12.0	4.5
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	23.7	11.6	11.9	19.2	19.0	19.4
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	6.7	5.2	1.5	5.5	8.4	2.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.0	1.3	2.7	3.2	2.1	4.4
Мэдээлэл холбоо	3.1	1.7	1.4	2.5	2.7	2.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5.2	2.0	3.2	4.2	3.2	5.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.0	0.5	0.5	0.8	0.7	0.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3.7	1.8	1.9	3.0	2.9	3.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.1	2.5	1.6	3.3	4.1	2.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	12.3	7.2	5.1	10.3	11.6	8.3
Боловсрол	13.5	3.4	10.0	10.9	5.5	16.4
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7.1	1.4	5.7	5.8	2.2	9.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.4	0.7	0.7	1.1	1.1	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6.9	3.2	3.6	5.6	5.2	6.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээ	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.4	0.2	0.2	0.3	0.3	0.4

Дүүргийн ажил эрхэлдэг хүн амын 19.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт ажиллаж байгаа нь хамгийн өндөр байна. Ажил эрхэлдэг хүн амыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай. Тухайлбал: уул уурхай, тээвэр агуулахын үйл ажиллагаа, барилга, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт ажиллагчдын 72-оос дээш хувь эрэгтэйчүүд байхад хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсрол, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагчдын 67-оос дээш хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 16. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Ажил эрхлэлтийн төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0
Цалин хөлстэй байнгын ажиллагч	77.7	74.3	81.1
Цалин хөлстэй түр ажиллагч	9.3	10.0	8.5

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	1.2	1.6	0.7
Цалин хөлстэй дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	0.0	0.0	0.0
Гүйцэтгэх гэрээлэгч	0.5	0.7	0.3
Аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч	0.8	1.1	0.5
Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	0.3	0.4	0.3
Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	0.4	0.5	0.4
Өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч	9.3	11.1	7.5
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	0.5	0.3	0.7

ХҮСНЭГТ 17. ДҮҮРГҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Ажиллах хүчний оролцооны түвшин			Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	59.3	64.6	54.7	40.7	35.4	45.3
Багануур	56.3	61.5	51.4	43.7	38.5	48.6
Багахангай	56.0	59.6	52.3	44.0	40.4	47.7
Баянгол	62.6	67.0	58.9	37.4	33.0	41.1
Баянзүрх	60.9	65.9	56.5	39.1	34.1	43.5
Налайх	51.0	57.0	45.4	49.0	43.0	54.6
Сонгинохайрхан	58.9	65.4	52.8	41.1	34.6	47.2
Сүхбаатар	56.7	61.5	52.5	43.3	38.5	47.5
Хан-Уул	62.1	66.7	58.2	37.9	33.3	41.8
Чингэлтэй	53.7	59.0	48.8	46.3	41.0	51.2

Баянзүрх дүүрэгт ажиллах хүчнээс гадуурх хүн ам 95.3 мянга байгаа нь өмнөх тооллогоос 6.7 хувиар буурчээ. Эдгээрийн 41.2 хувь нь эрэгтэй, 58.8 хувь нь эмэгтэй байв. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын шалтгааныг ангилбал: сургуульд сурдаг 38.5 хувь, тэтгэвэрт 26.3 хувь, хөдөлмөр эрхлэх чадваргүй 4.6 хувь, гэрийн ажилтай 13.4 хувь, тохирох ажил олдохгүй 9.5 хувь, ажиллах сонирхолгүй 0.3 хувь, бусад шалтгаанаар ажил эрхлээгүй 7.4 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 18. ДҮҮРГҮҮДИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН

Дүүрэг	Бүгд	15-24	25-34	35-44	45-54	55+
БҮГД	402 245	132 320	65 618	43 966	36 647	123 694
Багануур	8 691	2 921	1 089	837	967	2 877
Багахангай	1 236	404	175	150	112	395
Баянгол	56 854	19 159	9 176	5 370	4 386	18 763
Баянзүрх	95 332	33 198	15 868	10 255	8 401	27 610
Налайх	12 406	3 732	1 948	1 554	1 426	3 746
Сонгинохайрхан	90 537	30 172	14 908	10 041	8 368	27 048
Сүхбаатар	43 201	13 517	6 920	4 855	3 976	13 933
Хан-Уул	46 529	15 139	7 678	4 945	3 936	14 831
Чингэлтэй	47 459	14 078	7 856	5 959	5 075	14 491

АЖИЛГҮЙЧҮҮД

Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулж ажилгүйдлийн

түвшинг тодорхойлов.


Баянзүрх дүүргийн хэмжээнд 2020 онд ажилгүйчүүдийн тоо 25.2 мянгад хүрч, өмнөх тооллогын үеэс 11.2 мянган хүнээр буюу 80.0 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 19. ДҮҮРГИЙН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Он	Дүүрэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
		Ажилгүй-чүүд	Ажилгүйд-лийн түвшин	Ажилгүй-чүүд	Ажилгүйд-лийн түвшин	Ажилгүй-чүүд	Ажилгүйд-лийн түвшин
2010	Нийслэл	60 732	13.4	35 687	14.7	25 045	12.0
	Баянзүрх	14 003	12.9	8 229	14.0	5 774	11.5
2020	Нийслэл	85 198	14.5	45 739	15.2	39 459	13.8
	Баянзүрх	25 198	16.9	13 613	17.9	11 585	15.9

Улаанбаатар хотын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 14.5 болж, өмнөх тооллогын үеийнхээс 1.1 пунктээр өсч, улсын дүнгээс 4.6 пунктээр дээгүүр байна. (Улсын дүн 9.9 хувь байна). Харин Баянзүрх дүүрэгт ажилгүйдлийн түвшин 2020 онд 16.9 болж өмнөх тооллогын дүнгээс 4.0 пунктээр өсч, улсын дүнгээс 7.0 пунктээр өндөр байна. Дүүргийн ажилгүйдлийн түвшинг /хүйсээр/ нийслэлийн түвшинтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн хувь 2.7 пунктээр, эмэгтэйчүүдийн хувь 2.1 пунктээр нийслэлийн дүнгээс өндөр байгаа нь нь нэг талаас тус дүүрэгт орон нутгаас шилжих хөдөлгөөн их байсан, нөгөө талаас тэдэнд хотод шилжин ирээд ажлын байр олох боломж муу байдагтай холбоотой.

ЗУРАГ 16. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН



ХҮСНЭГТ 20. ДҮҮРГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР, 2020 ОН

Насны бүлэг	Эдийн засгийн идэвхгүй хүн ам							
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Ажиллах сонирхолгүй	Тохирох ажил олдохгүй байгаа	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	20.9	52.8	-	1.0	1.5	0.7	1.5	2.9
20-24	13.9	29.8	-	3.0	6.1	4.6	8.1	9.1
25-34	16.6	14.9	-	14.7	38.4	24.8	30.4	28.6
35-44	10.8	2.2	0.4	25.1	30.8	30.0	25.9	26.6
45-54	8.8	0.2	4.0	32.6	16.7	27.8	23.3	22.2
55-59	7.2	0.1	16.7	16.1	4.9	8.8	8.6	7.3
60+	21.8	0.0	78.9	7.5	1.6	3.3	2.2	3.3
ДҮН	100.0	38.5	26.3	4.5	13.4	0.3	9.6	7.4
15-19	100.0	97.1	-	0.2	1.0	0.0	0.7	1.0
20-24	100.0	82.6	-	1.0	5.9	0.1	5.5	4.9
25-34	100.0	33.3	-	4.1	31.6	0.5	17.6	12.9
35-44	100.0	7.4	0.9	10.8	38.2	23.3	0.9	18.5
45-54	100.0	1.0	11.9	16.8	25.5	1.0	25.2	20.7
55-59	100.0	0.3	61.1	10.2	9.1	0.4	11.4	7.5
60+	100.0	0.1	93.6	2.1	1.3	0.1	1.4	1.4

11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд гадаадад б, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг хуульчилсан байдаг. Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хүрээнд гадаадад оршин суугаа монгол улсын иргэдийн мэдээлэл цуглуулалтыг Монголд байх гэр бүлээс асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр (www.citizen.gov.mn) тоолуулахаар зохион байгуулсан юм.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр Баянзүрх дүүргээс гадаадад оршин суугаа 20 772 иргэн тоологдсны 45.8 хувь нь эрэгтэй, 54.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 12.4 хувь, 15-44 насныхан 72.3 хувь, 45-64 насныхан 14.8 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 0.5 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 8 нь хөдөлмөрийн насны хүн ам байна.

ХҮСНЭГТ 21. ДҮҮРГИЙН ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2020 ОН

2020				
Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа ¹
БҮГД	20 772	9 516	11 256	81.5
0-4	558	289	269	107.4
5-9	1 063	549	514	106.8
10-14	954	502	452	111.0
15-19	1 066	569	497	114.5
20-24	2 478	1 280	1 198	106.8
25-29	3 347	1 684	1 663	101.3
30-34	3 580	1 714	1 866	91.9
35-39	2 581	1 106	1 475	75.0
40-44	1 986	728	1 258	57.9
45-49	1 507	531	976	54.4
50-54	889	310	579	53.5
55-59	447	155	292	53.0
60-64	202	66	136	48.5
65-69	67	18	49	36.7
70+	47	15	32	46.9

Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 81.5 байгаа (45.8 хувь эрэгтэй, 54.2 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээсээ олон байгааг илтгэж байна. Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч, 35 наснаас эхлэн огцом буурчээ. 0-29 насныхны хувьд дийлэнх нь эрэгтэйчүүд байхад хөдөлмөрийн насны болон ахмад настнуудын хувьд эмэгтэйчүүд илүү байна.

ХҮСНЭГТ 22. ДҮҮРГИЙН ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Тоо	Бүгд	2020			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-с дээш жил
БҮГД	20 772	100:0	28.8	42.2	15.3	13.7
Солонгос /өмнөд/	5 715	100.0	31.4	44.5	13.7	10.4
Америк	4 043	100.0	21.2	41.6	18.5	18.7
Япон	1 795	100.0	37.8	40.4	10.7	11.1
Казахстан	348	100.0	41.7	46.8	8.0	3.5
Чех	844	100.0	24.4	38.6	14.6	22.4
Австрали	746	100.0	32.4	49.3	10.7	7.6
Хятад	679	100.0	34.6	44.6	11.8	9.0
Герман	1 279	100.0	30.2	44.1	13.3	12.4
Швед	576	100.0	25.0	43.1	20.1	11.8
Франц	437	100.0	11.2	32.0	28.6	28.2
Орос	927	100.0	42.2	42.9	8.5	6.4
Турк	206	100.0	30.1	45.1	15.5	9.3
Австри	230	100.0	16.5	35.7	25.7	22.1
Швейцар	298	100.0	25.5	39.9	18.1	16.5
Их Британи	269	100.0	13.0	26.0	24.5	36.5
Унгар	220	100.0	25.5	33.2	15.0	26.3

Канад	388	100.0	27.3	39.2	21.6	11.9
Энэтхэг	90	100.0	30.0	48.9	11.1	10.0
Польш	175	100.0	22.9	49.7	16.6	10.8
Ирланд	232	100.0	35.8	37.1	9.5	17.6
Бусад	1 275	100.0	26.5	39.1	20.2	14.2

Гадаадад тоологдсон иргэдийн 3 хүний 2 нь буюу 70.2 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 4 хүн тутмын 1 нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

12. ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, НӨХЦӨЛ


Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогоор орон сууц, тэдгээрийн дэд бүтцийн хангамжийн байдлыг нэлээд өөр өөр аргачлалаар тоолж ирсэн. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны сан хөмрөгийн тооллогыг 1969 онд анх удаа зохион байгуулж байжээ. Харин хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогуудад орон сууцны сан хөмрөгийн тооллого явуулаагүй, хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, өмчлөл болон эзэмшлийн хэлбэр, дэд бүтцийн хангамжийг хүн амын тооллоготой хамтатган явуулж байсан.

Энэ удаа хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, түүний нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулахаас гадна хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах зорилготой Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд улс орон даяар зохион байгуулж явуулсан.

СУУЦНЫ ТӨРӨЛ

Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийслэл Улаанбаатар хотод 411.4 мянган өрх амьдарч байгаагийн 104.8 мянган өрх /25.4%/ нь Баянзүрх дүүрэгт амьдарч байна. Дүүргийн нийт өрхийн 23.1 хувь нь уламжлалт сууц болох гэрт, 76.4 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

ЗУРАГ 17. ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 31.6 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 106.1 мянган сууц тоологдсон.


ХҮСНЭГТ 23. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019, 2020 ОН

Сууцны төрөл	Хүн байнга амьдардаг сууц /мян/		Өрхийн тоо	
	Сууцны тоо	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	106.1	100	104.8	100.0
Гэр	13.4	12.6	24.2	23.1
Байшин	92.7	87.4	80.1	76.4
Бусад сууц	-		0.5	0.5

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухайн сууцанд амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 42.5 хувь нь гэр сууц, 53.0 хувь нь сууцны тусдаа байшин, 3.3 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.6 хувь нь бие даасан тохилог сууц, 0.6 хувь нь нийтийн байр тоологдсон байна. Нийтийн зориулалттай 1 050 орон сууцны байшинд 74 534 сууц тоологдсон байна.

ЗУРАГ 18. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



ХҮСНЭГТ 24. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	мян. өрх	Дүнд эзлэх хувь	мян. өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	73.4	100	104.8	100.0
Гэр	23.8	32.4	24.2	23.1
Бусад	1.1	1.5	0.5	0.5
Байшин	48.5	66.1	80.1	76.4
Орон сууцны байшин	24.2	33.0	52.5	50.1
Бие даасан тохилог сууц	0.6	0.8	0.6	0.6
Сууцны тусдаа байшин	21.0	28.6	26.0	24.8
Нийтийн байр ¹	2.7	3.7	1.0	0.9

¹ оюутан, сурагчдын нийтийн байр, ажиллагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байрыг хамт авч үзэв.

Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 9.3 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 10.3 пунктээр нэмэгджээ. Энэ нь сүүлийн жилүүдэд нийслэл хотод гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцжуулах ажил хийгдэж байгаа, мөн өнгөрсөн арван жилд шинээр орон сууцны хорооллууд ихээр баригдаж байгаатай холбоотой юм.

Байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 31.6 мянган өрхөөр өссөн, үүнээс орон сууцанд амьдардаг өрхийн тоо 28.5 мянган өрхөөр, сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн тоо 5.0 мянган өрхөөр тус тус өсжээ. Эндээс байшинд амьдардаг өрхийн өсөлтийн дийлэнхийг орон сууцанд амьдардаг өрхийн өсөлт бүрдүүлж байгаа нь харагдаж байна.

СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР

Сууцны өмчийн хэлбэрийг тооллогод тодорхойлохдоо төрийн болон хувийн гэж 2 ерөнхий ангилалд хуваасан бөгөөд хувийн өмчийг дотор нь иргэний, аж ахуй нэгж байгууллагын гэж өмнөх тооллоготой ижил ангилсан.

ХҮСНЭГТ 25. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Төрийн өмчийн	Хувийн өмчийн				
				ААНБ-ын		Иргэний		
	мян. өрх	Бүгд	мян. өрх	Дүнд эзлэх хувь	өрх	Дүнд эзлэх хувь	өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	104.8	100.0	0.7	0.7	0.5	0.5	103.6	98.8
Гэр	24.2	100.0	0.0	0.0	0.1	0.4	24.1	99.6
Байшин	80.1	100.0	0.7	0.9	0.4	0.5	79.0	98.6
Бусад сууц	0.5	100.0	0.0	0.0	0.0	0.0	0.5	100.0

Дүүргийн нийт өрхийн 99.3 хувь нь хувийн өмчийн (98.8 хувь нь иргэний, 0.5 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) сууцанд амьдарч байна.

Харин гэрт суудаг өрх 100 хувь (99.6 хувь иргэний, 0.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын) хувийн өмчийн сууцанд амьдарч байна. Байшинд суудаг өрхийн 0.9 хувь нь төрийн өмчийн, 99.1 хувь (98.6 хувь нь иргэний, 0.5 хувь аж ахуйн нэгж, байгууллагын) хувийн өмчийн сууцанд амьдарч байна.

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

